

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр хавсралт

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/			
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.			
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК УБГД:9022001010, ҮЦКод:510 Утасны дугаар : 11-313747		
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж ХК		
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Үнэт цаасны зах зээлд үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа болон өөрийгөө зохицуулах байгууллага		
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	"Их Монгол хөлөг Аудит" ХХК		
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	350,463,539 ширхэг		
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Д.Нямдорж /Бүртгэлийн албаны ахлах мэргэжилтэн/ Х.Эрдэнэбүрэн /Захиргаа санхүүгийн газрын дарга/		
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/		
Санхүүгийн байдлын	Үзүүлэлт	1/1/2023	12/31/2023
	ХӨРӨНГӨ		
	Эргэлтийн хөрөнгө	2,296,778,319.64	904,842,895,157.05
	Эргэлтийн бус хөрөнгө	23,184,922,418.26	22,452,015,473.10
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	25,481,700,737.90	927,294,910,630.15
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
	Богино хугацаат өр төлбөр	998,657,547.96	881,588,538,249.72
	Урт хугацаат өр төлбөр	990,846,139.66	1,626,561,592.92
	Эздийн өмчийн дүн	23,492,197,050.28	44,079,810,787.51
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	25,481,700,737.90	927,294,910,630.15
	Үзүүлэлт	1/1/2023	12/31/2023

<i>Орлогын тайлан Үзүүлэлт</i>	Борлуулалтын орлого(цэвэр)	4,241,344,850.62	12,147,031,303.89
	Борлуулалтын өртөг		
	Нийт ашиг(алдагдал)	4,241,344,850.62	12,147,031,303.89
	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	769,747,808.22	10,337,515,816.10
	Орлогын татварын зардал	123,519,584.56	1,029,799,778.87
	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)	646,228,223.66	9,307,716,037.23
	Бусад дэлгэрэнгүй орлого	20,008,784,115.62	
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	20,008,784,115.62	
	Орлогын нийт дүн	20,655,012,339.28	9,307,716,037.23
<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>	Үзүүлэлт	1/1/2023	12/31/2023
	Өмч	23,130,593,600.00	35,046,353,900.00
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	20,021,146,332.29	20,021,146,332.29
	Эздийн өмчийн бусад хэсэг	446,321,902.02	446,321,902.02
	Хуримтлагдсан ашиг	(20,105,864,784.03)	(11,434,011,346.80)
	Нийт эздийн өмчийн дүн	23,492,197,050.28	44,079,810,787.51
<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>	Үзүүлэлт	1/1/2023	12/31/2023
	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(705,389,180.9)	896,919,408,256.00
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(423,392,511.6)	(575,344,268.00)
	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		11,915,759,800.00
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(997,653,812.73)	900,851,104,693.72
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,729,363,635.92	1,731,709,823.19
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,731,709,823.19	902,582,814,516.91
1.1.	<i>Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт</i>		
	<i>Хязгаарлалттай санал дүгнэлт</i>		
1.2.	<i>Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловруулсан байх/</i>		

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл		
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Нийт ашгийн хувь Цэвэр ашгийн хувь Өөрийн хөрөнгийн өгөөж	85% 77% 18%
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа Түргэн хөрвөх чадварын харьцаа Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа	1.31 1.03 20.04
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	<p>Монгол Улсын Их Хурлаас “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” 16 дугаар тогтоол, Засгийн газрын “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 244 дүгээр тогтоолоор Төрийн банк болон нэр бүхий 26 компанийн 34 хүртэл хувьд IPO хийж, нээлттэй аж ахуйн нэгж болгон олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангахаар шийдвэрлэсний дагуу 2022 оны 12 дугаар сарын 23-нд “Монголын хөрөнгийн бирж” нэмэлт хувьцаагаа олон нийтэд нээлттэй санал болгож, нээлттэй компани болсон. Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд системийн 5 банк болох Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Хас банк, Төрийн банк, Голомт банкууд нь 2023 оны 06 дугаар 30-ны өдрөөс өмнө нээлттэй компани болох үүргээ биелүүлж, олон нийтэд хувьцаагаа санал болгосноор нийт 446.79 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн. Түүнчлэн Монголын хөрөнгийн бирж үндэсний аж ахуйн нэгжүүдийн хувьцаа, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, өрийн хэрэгсэл зэрэг бүтээгдэхүүнүүдийг бүртгэн олон нийтэд санал болгож, 184.22 гаруй тэрбум төгрөгийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгууллаа.</p> <p>Улсын Их Хурлаас “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль” баталж, 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос “Монголын хөрөнгийн бирж” ХК-д уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосноор Монгол Улсад анхны уул уурхайн бүтээгдэхүүний бирж үүссэн түүхэн үйл явц өрнөж байна. Энэхүү үйл явцтай холбогдуулан МХБ арилжааны системийн шинэчлэлт хийн, үйл ажиллагаагаа өргөжүүлэв. Мөн МХБ-ээр арилжигдсан уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны үнийн мэдээллийг эх сурвалж болгон “Ашигт малтмалын нөөц ашигласны</p>	

		<p>төлбөр"/АМНАТ/ тооцдог болсон. МХБ-ээр дамжин экспортод гарах уул уурхайн бүтээгдэхүүний нэр, төрөл нэмэгдэж төмрийн баяжмал арилжаалж эхэлсэн бол манай хамт олон 2024 онд зэс болон бусад нэр төрлийн бүтээгдэхүүн арилжаалах бэлтгэл ажлыг хангаж байна. 2023 онд Монголын хөрөнгийн зах зээлийг гадаад улсуудад сурталчлах, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр БНСУ, Хонконг, БНХАУ улсуудад үйл ажиллагааг зохион байгуулж, Будапештын хөрөнгийн бирж, Шанхайн хөрөнгийн биржтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.</p> <p>Үүний зэрэгцээ дотоодын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 11.6 их наяд төгрөг болж, дотоодын нийт бүтээгдэхүүний 16.87 хувьд хүрээд байна.</p> <p>Хойшид гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улсын хөрөнгө оруулагчдыг Монголын санхүүгийн зах зээлд идэвхтэй оролцох боломж нөхцөлийг нэмэгдүүлэх, үнэт цаас, хөрөнгийн зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгох, оролцогч байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг сайжруулах, эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх зорилт тавин ажиллаж байна.</p>
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Тайлант хугацаанд зээл аваагүй болно.
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
4.	Цалин урамшууллын мэдээлэл	
МХБ ХК-ийн ТУЗ-ийн цалин урамшуулалд 135.5 сая төгрөг олгосон болно.		
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	

ТУЗ-ийн үүрэг

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь МХБ-ийн үйл ажиллагааны үр дүнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээдэг.

ТУЗ гүйцэтгэх захирлын ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх, томилох, дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах зэрэг үүрэгтэй. Компанийн 2022-2024 онд хэрэгжүүлэх стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж, удирдамж, зөвлөмжөөр хангаж ажиллалаа. Тайлант хугацаанд МХБ-ийн гүйцэтгэх удирдлагын баг үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилтоо хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих зорилгоор тогтмол хуралдсан байна. ТУЗ-ийн үүргийг "Монголын хөрөнгийн бирж ХК-ийн дүрэм" болон "Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам"-д тодорхой заасан байдаг.

ТУЗ-ийн хороод

МХБ нь ТУЗ-өөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий байнгын 4 хороотой ба эдгээр хороод нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор санал дүгнэлт гаргах үндсэн зорилготой. Хороодын үйл ажиллагааг "Компанийн дүрэм" болон "Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам"-аар тус тус зохицуулдаг.

ТУЗ нь дараах байнгын хороодтой:

- Нэр дэвшүүлэх хороо;
- Аудитын хороо;
- Цалин, урамшууллын хороо.
- Эрсдэл (комплаенс)-ын удирдлагын хороо

ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болно. Компанийн тухай хуульд ТУЗ-ийн хараат бус гишүүн нь аудитын хороонд ажиллахаар заасан байдаг.

ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, шинэчлэх

ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнийг бүрдүүлэхэд хараат бус үнэлгээ дүгнэлт гаргах зорилгоор нэр дэвшүүлэх хороог байгуулдаг. Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүдийн ур чадвар, туршлагыг хянан шалгаж, гишүүдийн ур чадвар МХБ-ийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлох, түүний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг үйл ажиллагааг хангаж ажиллахад зохистой эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгдөг. Энэхүү үнэлэлт, дүгнэлтэд үндэслэн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд шинээр оруулах гишүүнийг нэр дэвшүүлдэг. Гишүүдийг томилохоос өмнө Компанийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм журмын дагуу боловсрол, ур чадвар, өмнөх ажил эрхлэлтийн түүх, их хэмжээний зээлийн өртэй эсэх, гэмт хэрэгт холбогдсон эсэх зэрэг асуудлаар цогц судалгаа, шинжилгээг мөн хийдэг.

ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, улируулан сонгох

ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар 3 жилийн хугацаатай сонгод бөгөөд гишүүнийг улируулан сонгож болно. Чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан ТУЗ-ийн гишүүнийг орлох гишүүнийг нөхөн сонгох хүртэл ТУЗ түр томилж болдог. 2023 онд гишүүн С.Тулга, Ч.Дондогмаа, Д.Баянзул, М.Санжаадорж, Л.Наранчимэг, Р.Гандиймаа, А.Анар нар улиран сонгогдсон бол Д.Энхбаатар, А.Батпүрэв нар өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж, Г.Лхагвадорж, Г.Лхамдулам нарыг нөхөн томилсон. Харин Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар С.Тулга, Ч.Дондогмаа, Д.Баянзул, М.Санжаадорж, Л.Наранчимэг, Р.Гандиймаа, А.Анар, Г.Лхагвадорж, Г.Лхамдулам нарыг чөлөөлж, Д.Тогтохбаяр, Ж.Цогтбаяр, Ж.Бямбасүрэн, Т.Ганбаатар, С.Баянцогт, Р.Мөнхтөр, Н.Улаанхүү, Н.Отгончимэг, М.Банзрагч нарыг шинээр томилсон байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ТУЗ үйл ажиллагаагаа хэвийн явуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах зорилгоор ТУЗ-д шууд хариуцлага хүлээх нарийн бичгийн даргыг томилох үүрэгтэй. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх шаардлагатай бөгөөд ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилдог.

2023 онд уг албан тушаалыг эрхэлж байгаа этгээдэд өөрчлөлт орж, 2023 оны 05 дугаар сард шинээр томилсон ба холбогдох гэрчилгээг авсан байна..

6.

Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл

Компанийн үйл ажиллагаанд үүсэж болох эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах, эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж буй голлох баримт бичиг нь "Эрсдэлийн удирдлагын бодлого". Уг бодлогыг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн ТУЗ-өөс 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд уг баримт бичиг нь компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, стратеги зорилтыг хэрэгжүүлэх, урт хугацааны өсөлт, бизнесийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор байгууллагын үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тодорхойлох, удирдах, арга хэмжээ авах, үр дүнг хянаж, тайлагнах тогтолцоог бий болгох, эрсдэлийн соёлыг төлөвшүүлэх юм. Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичигт заасны дагуу материаллаг болон материаллаг бус нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлийн хүчин зүйлүүдийг дор дурдсаны дагуу 6 (зургаа) чиглэлээр төрөлжүүлэн ангилан авч үзсэн.

Эрсдэлийн ангилал	Өнөөгийн нохиол байдал	Авах арга хэмжээ
Стратегийн эрсдэл	<p>Мөнгөний захын хувьд бусад өрсөлдөгч нараа авч үзэхэд 2023 оноос хойш Төв банкны бодлогын хүү тогтмол 13 хувьтай байсаар ирсэн нь зах зээлд 15-20 хувийн хүүгийн өгөөжтэй банкны хадгаламж, бондууд болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зэрэг бүтээгдэхүүнүүд рүү хөрөнгө оруулагчдын мөнгөн урсгалыг татаж эхэлжээ.</p> <p>Хороонгийн биржийн Top-20 индексийн өгөөжийг харьцуулан авч үзвэл 2023 оны эхэнд 36,485 байсан бөгөөд 2 дугаар сарын 28-ны өдөр 40,836 нэгжид хүрсэн бөгөөд 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар 37,134 байна. Үнэт цаасны зах зээлийн хөрөнгө оруулагчид хамгийн өндөр өгөөж буюу 12 хувь байсан бөгөөд одоогийн байдлаар 1,8 хувийн өгөөжтэй байна.</p> <p>Иймд төв банкны бодлогын хүү нь үнэт цаасны зах зээлийн ТОП-20 индексийн өгөөжөөс тогтмол өндөр байгаа нь хөрөнгө оруулагчид мөнгөн хөрөнгөө банкны хадгаламж, бонд зэрэг илүү найдвартай ашиг өндөр санхүүгийн хэрэгсэл рүү шилжих эрсдэлтэй байна.</p>	<p>Үнэт цаасны зах зээлийн боломжийн талаар сурталчлах, өгөөжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах</p>
Үйл ажиллагааны эрсдэл	<p>Байгууллагын үндсэн албад болох Арилжаа, Хяналт, Бүртгэл, Гишүүн, Уул уурхай зэрэг нэгжүүдийн тайлан мэдээ, бүртгэлүүд нь гар аргаар хийгддэг, цаг хугацаа их зарцуулдаг, дата, мэдээллүүд тухайн мэргэжилтний ашиглаж буй компьютер, тоног төхөөрөмжид хадгалагдах зэрэг нь мэдээлэл дамжуулах, ашиглах, боловсруулах хурдад нөлөөлж, удаашралтай байгаа нь байгууллагад хүлээлт үүсэх, алдаатай мэдээ түгээх зэрэг процессын болон нэр хүндийн эрсдэл үүсэж болзошгүй байна.</p>	<p>Дотоод мэдээллийн нэгсэн сан үүсгэх, гар ажиллагааг хөнгөвчлөх программ хөгжүүлэх, мэдээллийн нэгдсэн сан бий болгон автоматжуулах, мэргэжилтэн боловсон хүчнийг хөгжүүлэх зэрэг чиглэлээр бодлого баримтлан ажиллах.</p>
Санхүүгийн эрсдэл	<p>Санхүүгийн албаны үйл ажиллагаанд Программ хангамж, түүний үйл ажиллагаанд доголдол үүсэх, ашиглалтын шаардлага бүрэн хангахгүй байх, мэдээлэл устах гар ажиллагаанаас үүдэн санамсаргүй байдлаар буруу мэдээлэл оруулах, хугацаа хойшлох ажлын ачаалал үүсэх зэрэг эрсдэлүүд байна.</p>	<p>Байгууллагын санхүү бүртгэлийн гар ажиллагааг бууруулах, автоматжуулан, алба газар нэгжийн уялдаа холбоог нэмэгдүүлсэн цогц</p>

	<p>Түүнчлэн уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа гүйцэтгэж эхэлсэнтэй холбогдуулан дэнчин байршуулах, дэнчингийн бүртгэл хөтлөх, буцаах, сунгах, гэрээний дагуу шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг автоматжуулсан программ хөгжүүлж нэвтрүүлээгүй байгаагын улмаас харилцагч нарын улс хоорондын өндөр дүнтэй мөнгөн гүйлгээ хугацаа алдах, төлбөр тооцооны хяналт, бүртгэлийг гар аргаар гүйцэтгэхэд цаг хугацаа их зарцуулах, механик алдааны улмаас хугацаа алдах, дэнчингийн мэдээлэл хугацаанд нь байршуулахад хүний нөөцийн дутагдалтай байх зэрэг санхүүгийн эрсдэлд орох магадлал их байна.</p>	<p>программ хөгжүүлэх хангамж</p>
<p>Мэдээллийн аюулгүй байдал, технологийн эрсдэл</p>	<p>Серверийн өрөөнд төхөөрөмж ажиллуулах шаардлага бүрэн ханаагүй, хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх үед зайнаас орж буй харилцагч нар нэг зэрэг хандсаны улмаас серверт хэт ачаалал үүсгэх, сүлжээ тасалдах, арилжааны системийн серверийн багтаамж дүүрэх, нөөцийн төхөөрөмжийн хомсдол үүсэх, сүлжээний карт, тэжээлийн блок гэмтэх, шаардлагатай үед асахгүй байх, түлш дуусах, серверт техник хангамжийн гэмтэл гарах зэрэг доголдол үүссэний улмаас анхлагч арилжааны үел систем ганах, зогсох, байгууллагын вэб сайт ажиллахгүй байх, үйлдлийн системд гарсан алдаа болон шаардлагатай тусламж үйлчилгээг авах боломжгүй болох эрсдэлүүд бий болж болзошгүй байна.</p>	<p>Байгууллагын серверийн өрөөний аюулгүй байдал, үндсэн үйл ажиллагааг саадгүй явуулахад ашиглагдах тоног төхөөрөмжүүдийн ажиллах орчин нөхцөл, шаардлага хангасан тусгай өрөөг засч бэлтгэх. Ашиглаж буй программ хангамжийн шинэчлэл, зай багтаамж, ачаалал даах чадвар нэмэгдүүлэх зэргээр шаардлагатай судалгаа хийж ажиллах.</p>
<p>Хууль эрх зүйн эрсдэл</p>	<p>Гэрээнд талуудын саналыг тусгагдахгүй байх, хугацаа хоцрох, хяналт сулрах, гүйцэтгэл бүрэн биелэгдэхгүй байх, баримт алдагдах, дутах, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны нийтлэг журам зөрчигдөх эрсдэлтэй.</p> <p>Мөн Баримт хадгалах шүүгээ, сейф лац, цоожгүй улмаас мэдээлэл алдагдах, устах албан баримт бичиг алдагдах, мэдээлэл задрах зэрэг асуудлууд үүсэх магадлалтай юм.</p>	<p>Үйл ажиллагаатай холбоотой гэрээний төсөлд хариуцсан газар, алба, нэгжийн удирдлага, мэргэжилтэн нарын саналыг тусгах, санхүү, хуулийн албаар хянуулах, баримтыг битүүмжтэй газар хадгалах, байгууллагын архивд жил бүр шилжүүлэх</p>
<p>Хяналт зохицуулалтын эрсдэл</p>	<p>Монголын хөрөнгийн биржээр 2012 оноос өмнөх арилжаалагдсан үнэт цаасны арилжааны хэлцлүүдийн дата "Перспект" программ нь ашиглалтаас гарсан компьютерт хадгалагдаж байгаа нь компьютер ажиллахгүй болох, улмаар хэлцлүүдийн мэдээлэл, арилжааны хяналт шалгалтын бүх дата устах,</p> <p>Нарийвчилсан шалгалтын тайлангийн хавтас цаасан хэлбэрээр байгаа тул норох, гэмтэх, балартах, устах, нууцын зэрэглэлийн мэдээллийг гуравдагч этгээдэд алдах,</p>	<p>2012 оноос өмнөх арилжааны мэдээллийг устахаас сэргийлэн хадгалах хамгаалах, арилжааны хяналт шалгалт хийх "MIT" системийн үйл ажиллагааг хэвийн ажиллахад тухай бүр анхаарч ажиллах</p>

Систем дээр арилжааны хяналт шалгалт хийх үед зарим харилцагчийн мэдээлэл бүрэн гарч ирэхгүй байх нь зах зээлийг урвуулан ашиглах үйлдлүүдийг тайлагнах боломжгүй болох зэрэг эрсдэлтэй байна

7. Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/

Сангийн яам 66%

8. Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл

байхгүй

9. Ногдол ашгийн мэдээлэл

Компани нь 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайоангийн цэвэр ашиг болох 8,699,165,845 төгрөгөөс нийт 4,349,252,518.99 төгрөгийг, нэгж хувьцаанд 12 төгрөг 41 мөнгөөр тооцож ногдол ашгийг хуулийн хугацаанд хувиарилсан.

10. Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн хамт олон "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдэж Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 21-р хороонд мод тарьж нэрэмжит төгөлтэй болсноос гадна байнга усалж тордож байна.

Мэдээлэл гаргагч этгээд бидэн мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ж.ЦОГТБАЯР

Албан тушаал: "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гарын үсэг:

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Х.ЭРДЭНЭБҮРЭН

Албан тушаал: "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-ийн захиргаа, санхүүгийн газрын захирал

Гарын үсэг: